

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮР ХУГАЦААГААР ЗОГСООСОН
ХУГАЦААНД “БАГШИЙН ЖУРНАЛ” ХӨТЛӨХ ЗААВАР

“Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор “бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалтын үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл зогсоон, суралцагчдад зориулан зохион байгуулж байгаа теле болон цахим хичээлийг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэх”-ээр шийдвэрлэсэн. Засгийн газрын энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн А/194 дүгээр тушаал батлагдсан.

Ерөнхий боловсролын сургуулийн танхимын сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс түр хугацаагаар зогсоож, 18 долоо хоногийн хугацаанд сургалтыг теле болон цахим хэлбэрээр зохион байгуулж байна.

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан танхимын сургалтын үйл ажиллагаа зогссон (2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл) хугацаанд “Багшийн журнал”-ыг хэрхэн хөтлөх зааврыг Боловсролын хүрээлэнгийн захирлын 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 56 дугаартай албан бичгээр аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газарт тус тус хүргүүлсэн.

Мөн Боловсролын хүрээлэнгийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалаар 2020 оны 5 дугаар сарын 04-29-ний өдрүүдэд “Бага, дунд, ахлах ангийн сурагчдад телевизээр заах хичээлийн агуулга”-ыг баталж www.mier.mn, теле хичээлийг econtent.edu.mn цахим хуудаснаа тус тус байршуулсан.

Энэ удаа Та бүхэнд хичээлийн жилийн үргэлжлэх хугацаа дуусгавар болж байгаатай холбогдуулан “Багшийн журнал”-ыг үргэлжлүүлэн хэрхэн хөтлөх талаар дараах зааврыг өгч байна.

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/490 дүгээр тушаалаар баталсан “Хичээлийн жилийн бүтэц”-ийн дагуу бага анги 32, дунд, ахлах анги 33 долоо хоног хичээллэх бөгөөд хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд үндэслэн бага ангийн багш 6 долоо хоног, дунд, ахлах ангийн багш 7 долоо хоногийн хичээлийн агуулгыг “Багшийн журнал”-д дараах байдлаар тэмдэглэнэ:

1.1. Боловсролын хүрээлэнгийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан “Теле хичээлийн агуулга, сэдэв”-ийг баримтлан 2020 оны 5 дугаар сарын 4-29-ний өдрийг хүртэлх 4 долоо хоногийн хичээлийн сэдэв, агуулгыг хөтлөх. Тушаалыг <https://bit.ly/bhtushaal> холбоосоор эсвэл www.mier.mn веб сайтын Мэдээлэл цэсний Тушаал хэсэгт хандаж харах боломжтой.

1.2. Энэ зааврын 1-д заасан хичээлийн жилийн үргэлжлэх хугацааг баримтлан 3 долоо хоног (бага анги 2 долоо хоног)-т телевизээр зохион байгуулсан хичээлийг давтах давтлага хичээлийг бичих.

Жишээлбэл, V ангид математикийн хичээл 5 цаг ордог гэвэл теле хичээлийн агуулгад 4 долоо хоногт 20 цаг, давтлага хичээлийн 2 долоо хоногт 10 цаг, нийт 30 цагийн хичээлийг багшийн журналд тэмдэглэнэ.

V ангийн математикийн хичээл дээр тасарсан цаг, теле хичээлийн болон давтах цаг, агуулгыг хэрхэн тооцоолохыг Загвар 1-д үзүүлэв.

Загвар 1

Анги/Тасар сан цаг	Цаг		с.з код	Теле хичээлийн сэдэв
	TV хичээл	Давтах		
V (15+5=20 цаг)	8	7+5=12	5.1.ж.	5 сарын 5 Тэгшитгэл, тэнцэтгэл биш
			5.1и. 5.1н.	5 сарын 8 Харьцаа, пропорцын бодлого
		
			5.4 5.1н.	Өөрийгөө үнэлээрэй. (Өгөгдөлтэй ажиллах)
V (10 цаг)	Давтлага хичээл (багшийн өөрийн жилийн сургалтын хөтөлбөрөөс үүссэн зөрөө, теле хичээлийн агуулгыг давтах)			

(A/10 тоот тушаалын Хавсралт II-ын нэгдүгээр нүүрт байгаа теле хичээлийн 8 цагийг нийт тасарсанаас хассан цаг.)

V ангид математикийн хичээл 5 цаг ордог гэвэл 4 долоо хоногийн нийт 20 цаг

4 долоо хоногийн теле хичээлийн агуулга

2 долоо хоногийн давтлагын цаг

(A/10 тоот тушаалын Хавсралт II-ын нэгдүгээр нүүрт байгаа 8 цаг)

Суурь боловсролын VI, VII, VIII, XI ангийн түүхийн хичээл дээр тасарсан цаг, теле хичээлийн болон давтах цаг, агуулгыг хэрхэн тооцоолохыг дараах Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1.

Анги/Тасар сан цаг	Цаг		Суралцахуйн зорилтын код/ суралцахуйн зорилт	Теле хичээлийг заах хугацаа
	ТВ хичээл	Давтах		
VI (7 цаг)	2	2	Код: 6.5.в. Түүхийн дурсгал, олдворыг ашиглан Монголын эртний улсуудын аж ахуй, хүмүүсийн амьдралыг дүрслэн тайлбарлах	5 дугаар сарын 04
			Код: 6.5. Монголын эртний улсууд бүлгийн бататгал	5 дугаар сарын 22
		3	Давтлага: Дээрх хичээлүүдийн давтан судалсан талаар бичиж болно	
VII (14 цаг)	3	5	Код: 7.5д. Зүүн Европын зарим нэр бүхий улсын түүхийн талаар мэдэх, танилцуулах	5 дугаар сарын 08
			Код: 7.5е. Дундад зууны европын сүм хийдийн талаар мэдэх, загалмайтны аян дайны шалтгаан, үр дагавар, сургамжийг тодорхойлох	5 дугаар сарын 18
			Код: 7.5ж. Баруун Европын улс орнуудын соёлтой танилцах, онцлог, нийтлэг шинжийг ялгах, танилцуулах	5 дугаар сарын 26
		6	Давтлага: Дээрх хичээлүүдийн давтан судалсан талаар бичиж болно	
VIII (14 цаг)	3	5	Код: 8.3л. Эзэнт гүрнүүдийн дорно дахиныг колончлох бодлогын учир шалтгаан, үр дагаврыг шинжлэн дүгнэх	5 дугаар сарын 06

			Код: 8.3м. XVIII-XX зууны эхэн үеийн өрнө дахины улс түмний амьдрал, соёлтой танилцах, танилцуулах	5 дугаар сарын 20
			Код: 8.3н. XVIII-XX эхэн үеийн дорно дахины улс орнуудын хүн ардын аж амьдрал, соёлын онцлогийг харьцуулах, дүрслэх	5 дугаар сарын 26
		6	Давтлага: Дээрх хичээлүүдийн давтан судалсан талаар бичиж болно	
IX (14 цаг)	3	5	Код: 9.4в. 1990 оны хувьсгалын үр дүнг Монголын улс төр, нийгмийн байдалд гарсан өөрчлөлтөөр зураглан харуулах	5 дугаар сарын 07
			Код: 9.4г. Энэ үед Монголын эдийн засагт гарсан өөрчлөлтүүдийг нэрлэх, өмнөх үетэй нь харьцуулах, дүгнэх Код: 9.4д. 1990-ээд оноос хойш монголчуудын оюун санааны амьдралд гарсан өөрчлөлтийг нэрлэх, өмнөх үетэй нь харьцуулах, дүгнэх	5 дугаар сарын 18
			Код: 9.4е. Монгол улсын гадаад харилцаа, түүний бодлогын өөрчлөлтийг ойлгох, ач холбогдлыг тайлбарлах	5 дугаар сарын 25
		6	Давтлага: Дээрх хичээлүүдийн давтан судалсан талаар бичиж болно	

Заавартай холбоотой асууж, тодруулах зүйл байвал Сурах бичиг, сургалтын орчны судалгааны секторын Д.Пунцагсүрэн 96003031, Ж.Дэнсмаа 99811878 нартай холбогдоно уу.

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН